

АГУУЛГА

1. ОРШИЛ.....	1
2. УУРХАЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	2
3. УУРХАЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	9
4. УУРХАЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	11
5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ.....	13
6. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	14
7. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	18
8. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	19
9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	20
10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	20
11. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	23
12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	24
13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	25
14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ.....	26
15. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ.....	26

1. ОРШИЛ

Дэнжийн элс-1 уулын хэсгийн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг 2024 онд батлагдсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, өмнөх жилүүдийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг үндэслэсэн БОАЖЯ-ийн сайдын 2019 оны 10 сарын 29 -ний өдрийн № А/618 тушаалаар батлагдсан “Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын тухайн жилд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 1, 3 дугаар хавсралтын дагуу боловсруулав.

Өмнөх оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх Нийслэлийн байгаль орчны газрын ажлын хэсэг төлөвлөгөөний хэрэгжилт дээр 98.5 % буюу хангалттай гэсэн үнэлгээ өгсөн.

Энэхүү Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь зөвхөн үйлдвэрийн 2026 оны үйл ажиллагааны хүрээнд хамаарах хэсгүүдтэй уялдан хийгдсэн бөгөөд тус төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд **31,780,000.00** төгрөг зарцуулахаар байна.

2. УУРХАЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Компанийн танилцуулга:

“Монголын Алт” (МАК) ХХК нь 1993 онд үүсгэн байгуулагдсан, үндэсний хөрөнгө оруулалттай, Монгол улсын тэргүүлэх компаниудын нэг билээ. Манай компани уул уурхай, барилгын материал үйлдвэрлэл, хөдөө аж ахуй, агаарын тээвэр, үл хөдлөх хөрөнгө, хэвлэл мэдээлэл зэрэг чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Үйл ажиллагааныхаа туршид улс, орон нутгийн төсөвт татвар төлөлтөөрөө тогтмол тэргүүлж ирсэн бөгөөд байгаль орчинд сөрөг нөлөө багатай, дэлхийд тэргүүлэх сүүлийн үеийн дэвшилтэт техник технологийг үйл ажиллагаа, үйлдвэрлэлдээ нэвтрүүлж, улс эх орныхоо хөгжил, эдийн засагт даацтай хувь нэмэр оруулах томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.

1.1 Уулын хэсгийн зорилго

Уулын хэсэг нь Монгол Улсыг үйлдвэржүүлэх бодлогын хүрээнд орон нутгийн эрдэс түүхий эдэд тулгуурласан жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, импортыг орлох, ажлын байрыг нэмэгдүүлэх, уул уурхай, барилгын салбарын өсөн нэмэгдэж буй түүхий эдийн хэрэгцээг хангах юм.

1.2 Ордын газар зүйн байршил:


Дэнжийн элс-1 хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий талбай дахь Дэнжийн элсний орд нь Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт, Улаанбаатар хотын төвөөс 60 км-т, Налайх дүүргийн төвөөс 15 км-т Зуун модны элсний ордтой зэргэлдээ оршино.

Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар MV015573A. Тусгай зөвшөөрлөөр олгогдсон нийт талбайн хэмжээ 33.77 га болно.

Анх Дэнжийн элс-1 нэртэй талбайн 12748Х тоот хайгуулын тусгай зөвшөөрлийг “Ашигт малтмалын тухай” Монгол улсын хуулийн дагуу АМГТХЭГ-ын Кадастрын бүртгэлийн төвийн даргын 2007 оны 2213 тоот шийдвэрээр “Монголын Алт” (МАК) ХХК- д “Гипфель” ХХК-ийн эзэмшиж байсан 9973Х тоот тусгай зөвшөөрлөөс хэсэгчилсэн байдлаар шилжүүлэн олгосон байна.

Хайгуулын ажлын дүнд "Дэнжийн элс"-ний ордын элсний бодитой (В) нөөцийг 221.327.36 м³, хайрганы бодитой нөөцийг (В) 5.675.06 м³, элсний (С) боломжтой нөөцийг 316.684.07 м³, хайрганы боломжтой нөөцийг 6.814.94 м³ гэж тогтоосон. Ордын нийт элсний нөөц нь 538011.37 м³, хайрганы нийт нөөц 12.490.0 м³ болж байна.

“Монголын Алт” (МАК) ХХК-ийн "Дэнжийн элс"-ний орд нь Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутаг дэвсгэрт байрладаг бөгөөд тус уурхай нь зам тээвэр, цахилгаан, харилцаа холбооны бүхий л хэлбэрийг ашиглах боломжтой, дэд бүтцийн хөгжил сайтай бүсэд оршдог. Уулын хэсгийн талбайн байршлын зургийг доор харуулав.



Зураг 1. Талбайн байршил

1.3 Цахилгаан хангамж:

Уулын хэсгийн тоног төхөөрөмжүүдийн цахилгаан эрчим хүч, ажилчдын байрны гэрэлтүүлгийг 35 кВ-ын ЦДАШ, 35/04 кВ-ын дэд станцаас хангаж байна.

1.4 Усан хангамж:

Элсийг угааж боловсруулах төхөөрөмжинд усан хангамж шаардлагатай ба уулын хэсгийн ажилчдад ундны усыг гүний худгийн уснаас хангаж байна. Тухайн оны ус ашиглалтын дүгнэлтийг мэргэжлийн байгууллагаар гаргуулж, гэрээг холбогдох сав газартай байгуулж гэрээний үүргээ биелүүлэн ажилладаг. Уулын хэсгийн хувьд элс угаах төхөөрөмжийн усны хэрэглээг багасгах зорилгоор ашигласан усаа хуримтлуулж дахин элс угаахад ашиглаж байна. Төслийн ажилчдын унд ахуйн хэрэглээний хувьд 1 хүн өдөрт 20 л/хоног ба төслийн хэрэгжих хугацаанд 42 хүн ажлын 240 хоног ажиллахаар байна

Хүснэгт № 1 Уулын хэсгийн хэрэглэх усны тооцоо

д/д	Зориулалт	Хоногийн хэрэглээ м ³	Жилийн хэрэглээ м ³	Тайлбар
1	Унд ахуй	8	2,920	42 ажилчин ажиллахаар тооцов
2	Үйлдвэрлэл	110	26,400	Нийт ашиглах усны хэмжээ 26.400 м ³ эргүүлэн ашиглах усны хэмжээ 92.45 %
3	Мод усалгаа	40	1,200.0	1000 ширхэг мод, 30 удаа
Нийт			29,320	

1.5 Уулын хэсгийн жилийн хүчин чадал

МАК Евро блок үйлдвэр нь 2026 онд 375,550 м³ блок үйлдвэрлэхээр төлөвлөсөн. Үүнээс хамааран “Дэнжийн элс-1”-ийн уулын хэсэг 113.050 м³ цэвэр элс үйлдвэрлэж нийлүүлэхээр тооцсон.

1.6 Ашиглагдах техник тоног төхөөрөмж

Уулын хэсэгт Орос, Герман, Япон зэрэг улсад үйлдвэрлэгдсэн техник, тоног төхөөрөмжийг ашигладаг. 2025 онд ашиглагдах техник, тоног төхөөрөмжийг дараах хүснэгтэнд харуулав.

Хүснэгт № 2. Уулын хэсэгт ашиглагдах техник, тоног төхөөрөмж

№	Техник, тоног төхөөрөмж	Хүчин чадал	Тоо хэмжээ
1	HITACHI -ZX360H экскаватор	1,6	1
2	XGMA 951H утгуурт ачигч	3м ³	1
3	TONLI	25 тн	2
4	TONLI	32тн	1
5	NORD BENZ- 25 тн	18 м ³	3
6	PICKUP үйлчилгээний машин	1 тн	1
7	Түлшний машин	5тн	1
	Нийт		10



Зураг 2. Hitachi -ZX360H экскаватор



Зураг 3. XGMA 951H утгуурт ачигч



Зураг 4. Tonly



Зураг 5. Nord benz- 25 тн

1.7 Элс ангилан ялгаж, угаах тоног төхөөрөмжийн ажиллагаа

Уулын хэсгээс автосамосвалаар бохир элс тээвэрлэж, элс хүлээн авах бункерт буулгаад, элс хүлээн авах бункерээс туузан дамжуургаар дамжин элс хуримтлуулах бункерт өгч хуримтлуулах бункерээс туузан дамжуургаар дамжин элс ангилан ялгах төхөөрөмжинд өгч элс хайргыг 5мм- ээс их, бага хэмжээтэй фракцаар ялгана.

Хаягдал хайрга буюу 5 мм-с дээш хэмжээтэй хаягдал хайрга нь овоолгын туузан дамжуурга дамжин хаягдал хайрганы овоолго үүсгэнэ. Ангилсан элсийг (5мм-с бага хэмжээтэй) угаах төхөөрөмжинд өгч холигч шурган голоор угааж элс хатаах төхөөрөмжөөс туузан дамжуургаар дамжин угаасан элсний овоолго үүсгэнэ.

Хүснэгт №3 Тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлтүүд

№	Техник, тоног төхөөрөмж	Хүчин чадал	Тоо хэмжээ /шт/
1	Хүрдэт шигшүүр	20 т/цаг	1
2	Туузан конвейр	130 т/цаг	3
3	Элс угаах төхөөрөмж XS1000*6000	140т/цаг	1
4	Элс угаах төхөөрөмж	200т/цаг	1

1.8 Ажиллах хүчний мэдээлэл

Ил уурхай нь 2-р сарын 15-12-р сарын 15 хооронд, Элс угаах төхөөрөмж 5-р сарын 1-нээс 9-р сарын 1 хүртэлх хугацаанд 2- ээлжээр тус тус ажиллана. Уурхай нь хүйтний улиралд 12 дугаар сарын 15 аас 2 дугаар сарын 15 хүртэлх хугацаанд амарна Жилд календарийн 240 хоног ажиллана. Ажиллагсад Монгол улсын хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу ажиллаж амарна.

Хүснэгт №4. Ажиллах хүний нөөцийн мэдээлэл

№	Албан тушаал	Орон тоо	Жилд ажиллах сар
1	Уулын ерөнхий инженер	1	12
2	Баяжуулагч инженер	1	12
3	Уулын инженер	1	12
4	Машин механизм	1	12
5	Уулын мастер	3	12
6	Цахилгааны мастер	1	10
7	Засварын мастер	1	10
8	Экскаватор оператор	3	10
9	Дугуйт ачигчийн оператор	6	10
10	Автосамосвол	6	10
11	Автобусны жолооч	1	10
12	Тусгай зориулалтын жолооч	1	12
13	Шигшүүрийн оператор	9	12

14	Гагнуурчин	3	12
	Нийт	35	

1.9 Барилга байгууламж

Ил уурхайн бүрэлдэхүүнд түүний үндсэн үйл ажиллагаатай шууд холбоотой дараах объектуудыг барьж байгуулсан. Үүнд:

- Элсний ил уурхай, хөрсний овоолго, шимт хөрсний овоолго
- Засвар үйлчилгээний төв
- Ажилчдын зоогийн газар
- Сэлбэг хэрэгслийн агуулах
- Захиргаа, ажилчдын түр амрах байр

Засварын газар, гараж

Уурхайн захиргаа, авто засварын газар зэргийг шаардлагатай тохиолдолд цахилгааны хэрэгслээр халаалтын асуудлыг шийддэг.

Сэлбэг хэрэгслийн агуулах

Сэлбэг хэрэгсэл болон материал хадгалах 2 агуулахтай ба тоног төхөөрөмж, тэдгээрийн эд анги, сэлбэг хэрэгсэл зэргийг хадгалах 50*50 метрийн хэмжээтэй. Ил уурхайн болон бусад хэсгүүдэд хэрэглэгдэх тоног төхөөрөмж, машин техникийн шатах тослох материалыг Улаанбаатар дахь төв Засвар үйлчилгээний төвөөс хангадаг ба шатахууныг Евро блок үйлдвэрт байрлах ШТС-аас зөөврийн шатахууны тэргээр хангаж байна.

Захиргаа ба ажилчдын хооллох түр амрах байр

2023 онд Засвар үйлчилгээний төвийг сайжруулж захиргааны байрыг давхар сайжруулан шийдэж өгсөн ба ажилчдын зоогийн газрыг шинээр 340,81 м2 талбайд барьж ашиглалтад оруулан ажилчдын ажиллах нөхцөлийг ханган ажиллаж байна



Зураг 6,7 Засвар үйлчилгээний төв, Зоогийн газар

Нэгдсэн менежментийн тогтолцоо: МАК Евро блок үйлдвэрийн уулын хэсэг нь 2022 оны 12 сарын 30 нд **ISO 9001:2015** “Чанарын менежментийн тогтолцоо”, **ISO 45001:2018** “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоо, **ISO 14001:2015** Байгаль орчны менежментийн тогтолцоо олон улсын стандартуудын аудитаа амжилттай хамгаалж баталгаажуулалтын гэрчилгээг гардан авч нэгдсэн менежментийн тогтолцоог хэрэгжүүлэн ажиллаж байна.



Зураг:9 Нэгдсэн менежментийн тогтолцооны баталгаажуулалтын гэрчилгээ


3. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Уур амьсгал

Уур амьсгалын хувьд Улаанбаатар хотынхтой адил, жилийн хамгийн хүйтэн хугацаа нь 1, 2 дугаар сарууд бөгөөд эдгээр саруудад агарын температур нь -2 -250С хэм хүрэх ба зарим тохиолдолд -350С, хамгийн дулаан нь 07 дугаар сард +25 +300С хэм заримдаа +350С хүрнэ. Хөрсний хөлдөлтийн гүн нь дунджаар 3-4м-т хэлбэлзэнэ. Салхи нь ихэнхдээ Улаанбаатар хотын нэг адилаар баруун, баруун хойноос чиглэлтэй салхилах бөгөөд жилийн дундаж салхины хурд 2.8-3.6 м/с байна. Ялангуяа шилжилтийн улирал буюу хавар намартаа салхи их зонхилно.

Хөрсөн бүрхэвч

Улаанбаатар хотын Налайх дүүргийн зүүн хойд талд орших Дэнжийн элс-1 нь Туул голын урд эргээс урагш 2.5 км –т нам уулсын хоорондох өргөн хөндийн дэнж газар байрлана. Талбайн газрын гадаргуу ерөнхийдөө зүүнээс баруун тийш намссан, тэгшивтэр гадаргуу зонхилж, урд талаар нь 50-70 см гүнтэй, 1.5-1.8 м өргөнтэй жалга зүсэж орж ирнэ. Гадаргуугийн үнэмлэхүй өндөр 1400-1440 метрийн хооронд хэлбэлзэнэ. Хөрс газарзүйн мужлалтаар Хэнтийн өмнөд тойрогт багтах ба талбайн хэмжээнд тэгшивтэр гадаргуу зонхилох ба үүнтэй уялдаж хөрсөн бүрхэвч нь жигд тархалттай 1 хэвжшинжид хамаарах 2-3 төрлийн хөрс тогтворжсон ба төслийн талбай орчимоор харилцан адилгүй зузаан давхаргатай хөнгөн шавранцар болон элсэнцэр механик бүрэлдхүүнтэй хурмал үетэй нугархаг /далд глейрхэг/ хүрэн хөрс тархана. Газрын өнгөн хэсэгт ургамлан бүрхэц 70- 80%-ийн бүрхэц үүсгэх ба хөрсний өнгөн гадарга жижиг үйрмэг чулуугаар бүрхэгдсэн онцлогтой.



Зураг 14 Монгол орны хөрс газар зүйн мужлал

Ургамлан нөмрөг

Налайх дүүрэг орчмын газар нутаг нь ургамалжилтын ангилалаар Бага хэнтийн уулархаг мужийн уулын хээрийн, нам толгодын хөндий, тал хээрийн бүсэд багтана. Налайхаас зүүн урагш Баянгийн овоо, Баян-Уул уулын хээрийн хөнгөн шавранцар хүрэн хөрстэй, жижиг үетэн-алаг өвст бүлгэмдэл зонхилох ба ботууль-хялганат-алаг өвст, чулуурхаг нам толгодоор үетэн алаг өвст- үетэн алаг өвс-шарилжит, үетэн шарилжит бүлгэмдэлтэй талхлагдсан талбай зонхилно.

Амьтны аймаг

Төслийн талбай нь төв суурин газар байрлах учир зэрлэг ан амьтан тохиолдох боломжгүй. Талбайд цөөн зүйл төв суурин амьдралтай шувууд хаа нэг тохиолдоно. Энд хон хэрээ, болжмор, тагтаа, шаазгай улаан хушуут жунгаа зэрэг цөөн зүйл жигүүртэн тохиолдоно. Дундад халхын тойрогт хамаарагдах Дэнжийн элс-1 ордын орчимд тархсан хөхтөн амьтдын зүйлийн бүрдлийг авч үзвэл махан идэштний багаас 2 зүйл амьтан, шавьж идэштний багаас 1 зүйл, туулай хэлбэртний багаас 1 зүйл, мэрэгчдийн багаас 3 зүйл, гар далавчтаны багаас 1 зүйлийг тус тус судалгаагаар тэмдэглэгдсэн.

Тусгай хамгаалалттай газар нутаг

Налайх дүүрэгт Чингисийн хүрээ, Түрэгийн Тоньюкүкийн хөшөө, Хан Хэнтийн Дархан цаазат газар, Горхи Тэрэлжийн байгалийн цогцолборт газар, Бүс нуур зэрэг түүхийн дурсгалт болон байгалийн үзэсгэлэнтэй газруудтай.

Нийгэм. Эдийн засаг

1912 оноос хятад худалдаачид нүүрс олборлож Нийслэл хүрээ лүү зөөж эхэлсэн. 1922 оны 12 дугаар сарын 25-нд Налайхын уурхай Улсын үйлдвэр болсон. 1932 он хүртэл Налайхын уурхай улирлын чанартай үйл ажиллагаагаа явуулж байгаад техник технологийн шинэчлэл хийгдэж 1954-1958 онуудад Налайхын Их уурхайг барьж байгуулсан байна. 1962 оны 5 сарын 10-нд Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 88-р зарлигаар Налайхын уурхайн төвийг Налайх хот болгон, хороо захиргаа хотын захиргаа болгон өөрчилж байв. 1962 оны 12 сарын 6-нд Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 202 дугаар зарлигаар Налайх хотод харьяалуулан Хонхор, Горхийн хороо захиргаадыг тус тус байгуулсан. 1965 оны 12 сарын 9-нд Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 250 дугаар зарлигаар Налайх хотыг район эрхтэйгээр Улаанбаатар хотод харьяалуулж Налайх хотын харьяаны Хонхор, Горхийн хороодыг татан буулгасан улмаар Улаанбаатар хотын Уурхайчдын хороо, Налайх хот, Налайх район зэрэг засаг, захиргааны нэгж болон нэрлэгдэж байгаад 1992 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн шинэ Үндсэн хуулиар

Нийслэлийн Налайх дүүрэг статустай болсон байна. Налайх дүүрэг нь Монгол улсын нийслэл Улаанбаатар хотоос зүүн урагш 36 км-т оршдог. Нийслэлийн Баянзүрх дүүрэг, Төв аймгийн Сэргэлэн, Эрдэнэ сумтай хиллэдэг, 68.7 мянган га нутаг дэвсгэрийг эзлэн оршдог. 2021-2022 оны байдлаар Засаг захиргааны 8 хороотой 10510 өрхийн 38929 хүн амтай байна. Нийслэл хоттой авто болон төмөр замаар холбогдсон. 120000, 45000 квт- ийн хос шугамаар Улаанбаатар хоттой холбогдсон, эрчим хүчний хэрэглээг 10 дахин нэмэгдүүлэх чадалтай өртөөтэй. Нийслэлийг цэвэр усаар хангаж буй дээд эх үүсвэртэй холбогдсон. Дулааны одоогийн хэрэглээг 3 дахин нэмэгдүүлэхэд хангах дулааны станцтай. Уул уурхайн, шилний үйлдвэр, эрчим хүч, авто, оёдлын мэргэшсэн инженер техникийн ажилтан, ажилчдын ажиллах хүчний нөөцтэй.

4. УУРХАЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Дэнжийн элс, Дэнжийн элс-1 уулын хэсгийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг 2024 оны БОННУ-ний нэмэлт тодотголоор дараах байдлаар тодорхойлсон. Байгаль орчинд үзүүлэх бохирдол, нөлөөллийн эх үүсвэр, шинж чанар, өртөгдлийн байдал

Хүснэгт 5,6,7

Нөлөөллийг тодорхойлох шалгуур үзүүлэлтүүд	Сөрөг нөлөөлөл үүсэж болзошгүй нөхцөлүүд
Төслийн байршилтай холбоотой шалгуурууд	
Хүний нөлөө болон байгаль, цаг уурын өөрчлөлтөд эмзэг, эсэх;	<ul style="list-style-type: none"> - Орон нутагт салхины нөлөө ихтэй ба хүчтэй салхи шуурга үе үе болдог; - Ил уурхайн олборлолтын технологийн үе шатуудаас болон элс угаах үйлдвэрийн үйл ажиллагаанаас богино хугацаанд эрчим ихтэй тоосжилт үүсэж болзошгүй; - Хөрсний эвдрэл үүсэж болзошгүй; - Газар хөдлөлтийн VII баллын бүсэд оршиж байгаа;
Болзошгүй хуримтлагдах нөлөөлөл үүсэх эсэх	Орон зайн хувьд нөлөөллийн цар хүрээ цаашид тэлэхгүй бөгөөд харин төсөл хэрэгжих явцад тухайн орчинд өөр төслүүд зэрэгцүүлэн хэрэгжих тохиолдолд хуримтлагдах нөлөөлөл
Тусгай хамгаалалттай газар нутаг, түүх, соёлын дурсгалт зүйлүүдэд нөлөөлөл үүсэх	Төслийн талбай нь ГТБЦГ-ын хязгаарлалтын бүсээс урагшаа 1.6 км зайд байрлана.
Төслийн БО-ны нөлөөллийн урьдчилсан үнэлгээнд авч үзсэн асуудлууд	
Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл: <ul style="list-style-type: none"> - Бохирдуулагч болон аюултай, хортой бодис ялгаруулах, эсэх - Дуу чимээ, доргио чичиргээ, дулааны нөлөөлөл, цахилгаан соронзон цацраг үүсгэх, 	Агаарын чанарт сөрөг нөлөө үзүүлэх дараах эх үүсвэрүүд байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Ил уурхайн ачилт, тээвэрлэлтээс үүсэх тоосжилт; - Элсийг Евро блокын үйлдвэр лүү хүргэх тээвэрлэлтээс үүсэх тоосжилт; - Дуу чимээ болон доргилт үүснэ;
Усан орчинд үзүүлэх нөлөөлөл:	Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөө: <ul style="list-style-type: none"> - Ашиглалтын үед шаардагдах технологийн хэрэгцээний болон ахуйн хэрэглээний усыг талбайд гаргасан 3 гүний худгаар хангана/ус

<ul style="list-style-type: none"> - Гадаргын болон газрын доорх усны нөөцийн хомсдол үүсэх, эсэх; - Цэнгэг усны нөөцийг ашиглах, эсэх; Ус бохирдуулах, эсэх; 	<p>хэрэглээг хангаж чадахгүй үед Евро блокын үйлдвэрийн худгууд болон конденсацгийн уснаас хангахаар төлөвлөж байгаа/;</p> <ul style="list-style-type: none"> - Ахуйн бохир усыг цооногт хадгалах үед ханаар нэвчих, дүүрсэн үед халих замаар хөрсөнд нэвчих; <p>Ил уурхай, үйлдвэрийн технологийн усны хэрэглээ ба унд- ахуйн зориулалтаар хоногт 1345.6 м³, жилд 229,128 м³ цэвэр ус зарцуулахаар байна.</p>
<p>Газрын хэвлий</p>	<ul style="list-style-type: none"> - уурхайн эцсийн хүрээнд 120.9 мян.м³ хөрс байх бөгөөд хөрс хуулалтын дундаж коэффициент 0.04 м³/м³ байна. Уурхайн хүрэн дэх нийт уулын цулын хэмжээ 3.3 сая.м³ байна. <p>0.5 метр зузаан хөрсний үеэр хучигдсан бөгөөд ашиглалтын хугацаанд тээвэртэй ашиглалтын технологи (Урвуу утгуурт экскаватор, автосамосвалын хослол) ашиглан Дэнжийн элс-1 талбайгаас 105.9 мян.м³, Дэнжийн элс талбайгаас 15.01 мян.м³, нийт 120.91 мян.м³ хөрс хуулалт хийж гадаад болон дотоод овоолго үүсгэнэ.</p>
<p>Хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл:</p> <ul style="list-style-type: none"> - Хөрс эвдрэх эсэх; - Хөрс бохирдох эсэх; Хөрс доройтох, цөлжих эсэх; 	<p>Хөрсөн бүрхэвчид дараах сөрөг нөлөөллийг үзүүлнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Ил уурхайн хөрс хуулалт, тээвэрлэлтийн үед талхалж доройтуулах; - Ил уурхайн машин механизмаас тос, шингэн асгарах; - Хатуу хог хаягдал гарах; - Дотоод, гадаад зам үүсгэснээр хөрс эвдрэх; <p>Уурхай, барилга байгууламжийн нөлөөгөөр хөрсөн бүрхэвч эвдэгдэх;</p>
<p>Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөө:</p> <ul style="list-style-type: none"> - Ургамлан нөмрөг, ой мод өртөх эсэх - Ховор, нэн ховор ургамлын төрөл зүйл өртөх эсэх 	<p>Ургамлан нөмрөгт дараах сөрөг нөлөөлөл үзүүлэх нөхцөлтэй.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Хөрс хуулснаар ургамлан нөмрөг биет хэмжээгээр устаж, тодорхой хэмжээний газар талбайд нөмрөг ургамалгүй болох; - Газрын хөрс талхлагдсан газруудад ургамлан нөмрөг халцрах; - Уурхайлалтын үеийн тоосны нөлөөгөөр ургамлын ургах орчин доройтох; <p>Төсөл хэрэгжих талбайд ховор болон нэн ховор ургамал тэмдэглэгдээгүй тул төрөл зүйлд нөлөө үзүүлэхгүй.</p>
<p>Ан, амьтанд үзүүлэх нөлөөлөл:</p> <ul style="list-style-type: none"> - Зэрлэг амьтдын амьдрах орчныг доройтуулах, эсэх; <p>Ховор болон нэн ховор амьтан өртөх, эсэх;</p>	<p>Ан амьтдад сөрөг нөлөө үзүүлэх дараах нөхцөлүүд байна.</p> <ul style="list-style-type: none"> - Үйл ажиллагааны үед төслийн талбай орчмын амьтад дүрвэж дайжих; - агаарын цахилгаан дамжуулах шугам сүлжээнд шувуу өртөх; - дуу чимээний нөлөөгөөр ан амьтад дайжих, амьдрах орчин нь өөрчлөгдөх; - Тунгаагуур нуурны уснаас мал амьтан уух <p>Тоосжилтоос мал, амьтанд сөргөөр нөлөөлөх;</p>

Төслийн байгаль орчны нөлөөллийн гол шалгуурууд болон урьдчилан тодорхойлсон сөрөг нөлөөллийн хэлбэр, эрчим, үргэлжилэх хугацааг магадлан жагсаах аргаар үнэлж дараах хүснэгтээр үзүүлж байна.

ТАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

2026 онд Төв аймгийн Сэргэлэн суманд байрлах “Монголын алт” (МАК) ХХК–ийн Евро блок үйлдвэр нь 375,550 м3 блок үйлдвэрлэхээр төлөвлөсөн байна. Үүнээс үзвэл “Дэнжийн элс” уулын хэсэг нь 126.500 м3 элс олборлож, 113.050 м3 цэвэр элс угаан баяжуулж МАК Евро блок үйлдвэрт нийлүүлэхээр тооцов.

Дээр дурьдсан төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаанаас гарч болзошгүй сөрөг нөлөөллүүдийг БОННУ-ний зөвлөмжүүд дээр үндэслэн тодорхойлж тэдгээрээс урьдчилан сэргийлэх, түүнийг багасгаж бууруулах арга замыг энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд багтаасан болно.

Зорилго: Уулын хэсгийн үйл ажиллагаанаас гарах сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний дагуу төлөвлөгөөт ажлуудыг авч хэрэгжүүлэн нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгахад оршино.

Дээрх зорилгыг биелүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллана. Үүнд:

- Байгальд шууд болон шууд бус хэлбэрээр үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, байгаль орчны төлөв байдлыг сайжруулах, хэвийн хадгалах, хамгаалах
- Байгаль орчны хяналтаар илэрсэн эрсдэл, сөрөг нөлөөллийг цаг алдалгүй илрүүлж, арилгах бууруулах арга хэмжээг зохион байгуулах
- Монгол улсын Байгаль орчны багц хуулийн хэрэгжилтийг хангах.
- Уулын хэсгийн орчны ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, нөхөн сэргээх, арчилгаа, тордолгоог сайжруулах, тогтмолжуулах
- Байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арилгах талаар заавар зааварчилгааг ажиллагсдад сургалтыг хэлбэрээр өгөх.
- Дүүргийн удирдлага, хяналтын байгууллага, ард иргэдтэй байгаль хамгаалах асуудлаар зөвлөлдөж тэдний саналыг авч хамтран ажиллах
- Хог хаягдлын менежментийг сайжруулах

6. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Энэхүү төлөвлөгөөний гол зорилго нь дээр тодорхойлсон голлох сөрөг нөлөөллүүдийг бууруулахад оршино.

Хүснэгт 9 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1. Агаарын чанар									
1.1	Тээврийн хэрэгслийн яндангаас утаа болон хорт хий ялгарах	Дизель түлш ашигладаг дотоод шаталт хөдөлгүүрүүд болон машинуудыг ашиглаагүй үед сул асаалттай байлгахгүй байх, шаардлага хангахгүй байгааг нь шинэчлэх	Тээврийн хэрэгслүүд Хүнд машин механизм-8 ширхэг Суудлын машин-2 ширхэг	ш	-	10	Үйл ажиллагааны зардал	Жилд 1 удаа	Байгаль хамгаалах тухай хууль Агаарын тухай хууль Агаарын чанарын стандарт MNS4585:2016 MNS4990:2023 MNS5013:2009
1.2	Уурхайн ашиглалтын үйл ажиллагааны үед эвдэгдсэн газруудаас салхи ба техникийн нөлөөгөөр тоос үүсэх	Тоосны дэгдэлтийг бууруулах зорилгоор усалгаа хийх	Уурхайн 1.5 км зам талбай	удаа	Үйл ажиллагааны зардал		Дулааны улиралд тогтмол		
1.3	Уурхайн ашиглалтын үйл ажиллагааны үед эвдэгдсэн газруудаас салхи ба техникийн нөлөөгөөр тоос үүсэх	Шимт хөрс болон, хөрсний овоолгын гадаргууг нягтруулах, гадаргууг тэгш бус болгох, чийгшүүлж байх; зүлэгжүүлэх зэргээр тоосжилт үүсгэхгүй байх	Шимт хөрсний овоолго	м2	2000	400	800,000.00	Сард 1 удаа	
1.4	Хүнд даацын машин механизмын хөдөлгөөнөөс тоосжилт үүсэх	Хурдны хязгаар 40км/ц-аас хэтрэхгүй байхаар хязгаарлах зааварчилгаа өгч, тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах	Уурхайн 1.5 км зам талбай	-	Үйл ажиллагааны зардал		Тогтмол		
1.5	Уурхайн үйл ажиллагааны явцад агаарт ялгарч буй хүлэмжийн хий	Үйл ажиллагаанаас агаарт хүлэмжий хий дэгдэж буйг бүртэх, тоолох, мэдээллийг сар бүрийн 10-ний дотор Байгаль орчин тогтвортой хөгжлийн газарт мэдээллэх	Scope-1, Scope-2	ш	0	12	0	Сар бүрийн 10-нд	
НИЙТ							2,000,000.00		

2. Гадаргын болон газрын доорх усны нөөц									
2.1	Усны хэрэглээнээс газар доорх усны нөөцийн хомсдол үүсэх	Төслийн нийт усны хэрэгцээг багасгах, эргүүлэн ашиглах усны хэмжээг зорилтод түвшинд байлгах, нэмэлт боломжуудыг судлах, усны зохистой ашиглалтын талаар сургалт явуулах.	Уурхайн 30 ажилтан	ш	50,000.0	1	50,000.0	1-р улирал	Усны тухай хууль Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS0900:2018
2.2		Гүний худгийн тоног төхөөрөмж, эрүүл ахуйн бүсийн хамгаалалтыг тогтмол шалгаж сайжруулалт хийх, ойр орчныг цэвэрлэх	Гүний худаг	ш	150,000.0	3	450,000.0	2.3-р улирал	
2.3		Усны чанар, нөлөөллийн бүсэд хамаарах худгийн тооллого, мониторинг хийх	Налайх дүүргийн Байгаль хамгаалагч, БО-ний мэргэжилтэн	ш	125,000.0	2	250,000.0	2.3-р улирал	
2.4		Усны хэрэглээг багтагдсан загварын дагуу тогтмол бүртгэж, хяналт тавьж ажиллах	Баяжуулах үйлдвэрт ашиглаж буй 2 худаг Унд ахуйд ашиглаж буй 1 худаг	хоног	-	300	Үйл ажиллганы зардал	Өдөр тутам	
2.5	Хур бороо, үерийн усаар төслийн талбай дахь хог хаягдал, шатах тослох материал, химийн бодисын алдагдал, сав баглаа боодлын хаягдал угагдан хөрсөнд нэвчиж улмаар газрын доорх усны чанар, найрлагад өөрчлөлт оруулж бохирдуулах	Шатах тослох материал алдагдаж болзошгүй эх үүсвэрүүд болон машин техникийн бүрэн бүтэн байдал, хог хаягдлын хадгалалтад тогтмол хяналт тавих, асгарч алдагдсан тохиолдолд ашиглах шаардагдах хэрэгсэл, материалыг бэлтгэх, бэлэн байлгах	Авто зогсоол Хогийн цэг орчим	удаа	20,000.0	5	100,000.0	Сард 2 удаа	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны А-230/127 дугаар хамтарсан тушаалын хавсралт

2.6	Хаягдал бохир усаар дамжин үүсэх бохирдол	Ахуйн бохир усны цооногийн ашиглалт, хяналтыг тогтмол хэрэгжүүлэх, бохир ус зайлуулах гэрээг байгуулан стандартын дагуу нийлүүлэлтийг хий	Бохир усны цооног	ш	-	1	Үйл ажиллгааны зардал	Тээвэрлэлт хийх хуваарийн дагуу	Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх бохир ус MNS6561:2024
2.7		Бохир усны бодит хэмжээг тогтоох, хэрэглээ ба нийлүүлэлтийн хяналтыг сайжруулах зорилгоор тоолууржуулах	Бохир усны цооног	ш	-	1	Үйл ажиллгааны зардал	4 сард	Байгаль орчин, ногоон хөгжлийнсайдын 2013 оны 05 дугаар сарын 16-ныөдрийн А-156 тоот тушаалын хавсралт
НИЙТ							850,000.0		
3. Хөрсөн бүрхэвч									
3.1	Газрын хэвлий болон үржил шимт өнгөн хөрс эвдрэлд өртөх	Хяналтгүйгээр газар хөндөхөөс сэргийлж аливаа газар хөндөх үйл ажиллагааг эхлүүлэхийн өмнө газар хөндөх зөвшөөрөл авах, газар зүйн мэдээллийн санд бүртгэх хяналт тавих	Уурхайн талбай	хоног	-	-	Үйл ажиллгааны зардал	Өдөр тутам	MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 3297:2019 Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх MNS 6147 : 2010 Байгаль орчны
3.2		Хөрс саармагжуулах талбайн ашиглалтад хяналт тавьж талбайн цэвэрлэгээг тогтмол хийх	Хөрс саармагжуулах талбай Хаягдал тос цуглуулах цэг	ш	17,500.0	12	210,000.00	Сард 2 удаа	
3.3	Хуулсан шимт хөрс салхи, усны нөлөөгөөр элэгдэхээс сэргийлэх	Шимт болон шимэрхэг хөрсийг алдагдахаас хамгаалж хадгалах талбайг зөв тодорхойлох, овоолгыг зөвүүсгэхэд хяналт тавих (2 метрээс өндөргүй овоолох, 60 метр тутамд 8 метр өргөнтэй зам үлдээх)	Шинээр баригдах засварын байр	м2	-	-	Үйл ажиллгааны зардал	Барилгын ажил эхлэх үед	

3.4	Ахуйн хог хаягдлыг зориулалтын цэгт төвлөрүүлж графикт хугацаанд ачиж зайлуулахгүй байх зэрэг нь хөрсний бохирдолыг бий болгоно.	Уурхайн талбайд ахуйн болон бусад хатуу шингэн хог хаягдлыг ил задгай хаяуулахгүй байх, хяналт тавьж, улирал бүр тайлан гаргах	Уурхайн талбай	тоо	12	110000	1,320,000.0	14 хоногт 1 удаа	бохирдол, бохирдлын хяналт ба хамгаалалт -
НИЙТ							1,530,000.0		
4. Амьтаны аймаг									
4.1	Амьтны аймгийн доройтол, алдагдал үүсэх	Үйлдвэрийн талбайд үзэгдэж буй амьтаны үзэгдлийг бүртгэх, шаардлагатай тохиолдолд даруй арга хэмжээ авах	Уурхайн талбай	тоо	Үйл ажиллганы зардал			Тухай бүр	МАК Евро блок үйлдвэрийн НМТ-ний баримт бичиг
4.2		МУ-ын улаан ном, бүс нутгийн болон ОУ-ын улаан данс (IUCN) хамгаалагдсан ховор, нэн ховор зэрлэг амьтдын зурагт хуудас бэлтгэн ажилчдад мэдлэг олгох	Уурхайн 30 ажилтан	тоо	100000	1	100,000.0	Жилд 1 удаа (3-р улирал)	Амьтны тухай хууль
НИЙТ							100,000.0		
5. Ургамлан нөмрөг									
5.1	Үйлдвэрийн барилга байгууламж, зам талбай, үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилт нь ургамлан нөмрөгт сөргөөр нөлөөлөх	Уурхайн талбайд нөхөн тарилт хийж, зүлэгжүүлэх	Гал тогооны урд талбай	м2	2000	100	200,000.0	5-р сард	MNS 6260:2020 Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих, арчлах
5.2		Төслийн дотоод болон гадаад талбайн ургамалжилтийн мэдээг цуглуулах байнгын мониторинг цэг байгуулах	Үйлдвэрийн талбай Эталон цэг	тоо	50000	2	100,000.0	Жилд 2 удаа	Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль
НИЙТ							200,000.0		
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний нийт зардал							3,480,000.0		

7. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Уулын хэсгийн техник эдийн засгийн үндэслэлийн V-р бүлгийн Байгаль орчин, нөхөн сэргээлт, хаалтын хэсэгт уурхайн ашиглалт явуулсан талбайг хөдөө аж ахуйн чиглэлээр нөхөн сэргээхээр тусгасан ба шиглагдсан талбайн нөхөн сэргээлт, цаашдын ашиглалтын нөхцөл бүрдүүлэх ажил хөдөө аж ахуйн чиглэлээр тэгшилж засах талбайн гадаргууд зохистой өнцгийг (хэвгийг) үүсгэж бүрдүүлнэ.

Уулын хэсгийн уулын ажил 2017 онд эхэлсэн ба Техник эдийн засгийн үндэслэлээр эхний 5 жилд биологийн нөхөн сэргээлтийн ажил хийгдэхгүй. Гэвч уулын ажлын явцад шимт хөрсний овоолго болон хоосон чулуулгийн гадаад овоолгын техникийн нөхөн сэргээлтийн стандарт болох MNS 5917:2008-ын дагуу өндөржилт болон налуу, тогтвортой байдлыг ханган ажиллана.

Ашиглалтын үеийн техникийн нөхөн сэргээлтээр уурхайн хоосон орон зайг дүүргэх, тэгшлэх, хэлбэржүүлэх, ухашийн хажууг налуулах болон шимт хөрсөөр хучих, суваг шуудуу татах зэрэг ажлууд хийгдэнэ. Уурхайн ойр орчмын зам, талбайд үүсэх хөрсний эвдрэл, гэмтлийг тэгшлэх, түрэх зэрэг ажлуудыг гүйцэтгэнэ.

Ашиглалтын үеийн биологийн нөхөн сэргээлтээр уурхайн шимт хөрсний овоолгыг Хөдөө аж ахуйн чиглэлээр нөхөн сэргээхэд бэлдэж тэгшилж талбайн гадаргууд зохистой хэвгийг үүсгэх ажлууд нэмж хийгдэх тул уурхай эзэмшил талбайн шаардлагатай газруудад салхинаас хамгаалах, тоосжилтыг бууруулах зорилгоор мод, бутаар нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэнэ.

Хүснэгт 10 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Техникийн нөхөн сэргээлт	Уурхайн ашиглалт явуулах талбайгаас хуулсан хөрсийг стандартын дагуу овоолго руу тээвэрлэх	Хөрсний овоолго	м3	-	Үйл ажиллагааны зардал		5-9 саруудад	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль MNS 5914 : 2008 Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, Монгол Улсын стандарт MNS 5917 : 2008 Уул Төслийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт
2	Биологийн нөхөн сэргээлт	Шимт хөрсний овоогын хөрсний үржил шим алдагдхаас сэргийлэн олон наст зүлэгний үр тариалах	Шимт хөрсний овоолго	м2	4000	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлвөлгөөнд тусгагдсан		3-р улирал	

3	Орчны эрүүл төрхийг бүтээх, агаар дахь тоосны хэмжээг багасгах, Амрах, тухтай байх орчныг бүрдүүлэх, орчин тойрны харагдах байдлыг сайжруулах	Уурхайн нийт зүлэгжүүлсэн талбайн шаардлагатай газруудад нөхөн тарилт хийх,	Зоогийн газрын урд талбай	м2	100			2.3-р улирал	Техникийн ерөнхий шаардлага, MNS 5918 :2023 Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага
4		Уурхайн өмнө жилүүдэд тарьсан модны усалгаа, арчилгаа	Уурхайн талбай	ш	1620	-	Үйл ажиллагааны зардал	3-р улирал	
5		Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд Төв аймгийн нутагт мод тарих	Налайх дүүрэг 5-р хороо	ш	100	3,000.00	300,000.00	Хавар болон намрын тарилалт	
Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний нийт зардал							300,000.0		

8. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ гэж дүйцүүлэн хамгаалахаар тогтоогдсон газар нутагт сонгон авсан биологийн олон янз байдлыг хамгаалах, сайжруулахад чиглэгдсэн хамгааллын менежментийн багц арга хэмжээ юм. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд тухайн газрын биологийн олон янз байдал хэвийн нөхцөлөөс илүүтэй сайжирсан байх нь дүйцүүлэн хамгааллын эцсийн зорилго болно.

Бид дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд хийгдэх ажлыг нөлөөллийн бүс, үйл ажиллагаа явуулж буй нутаг дэвсгэрт чиглэсэн талбайг сонгох хүсэлтэй байгаагаа илэрхийлэн 2025 оны 10 сарын 22-ний өдөр Нийслэлийн байгаль орчны газар болон Налайх дүүргийн засаг даргын саналаа ирүүлсэн байна. Энэхүү санал нь 2025-2028 он дуустал хийгдэх 7,5 га талбайд ногоон байгууламж бий болгох билээ.

Хүснэгт 11 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Үйл ажиллагаа	Зорилтууд	Хугацаа	Зардалын тооцоо
1	Ажлын даалгавар боловсруулж санал авах	1. Ажлын даалгавар боловсруулах	02.20 өдөр	2025-2028 он НИЙТ 80,000,000.00 (2026 онд 20 сая)
		2. Холбогдох удирдлагуудаас санал авах	02.20-03.02	
2	Захиалга үүсгэх	1. Захиалга үүсгэх	03.02-03.10	
		2. Хангамжаас сонгон шалгаруулалт хийх	03.10-03.31	
3	Гэрээ байгуулах	Сонгогдсон байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулах	03.31-04.15	
4	Ажлыг эхлүүлэх	Ажил эхлэх	4.20 өдөр	

9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжүүлэх нутаг дэвсгэрийн уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд олборлолт эхлэхээс өмнө 2012 онд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн дагуу ШУА-ийн Археологи ба Палеонтологийн хүрээлэнгээр хайгуул, судалгааг хийлгэсэн бөгөөд тус хайгуул судалгаагаар археологи, палеонтологийн ямар нэгэн олдворт зүйл байхгүй гэсэн дүгнэлт гарсан.

Төслийн хамрах хүрээ нь Улаанбаатар хотын Налайх дүүргийн барилга байгууламж, үйлдвэрлэлийн төвлөрсөн хэсэгт хамаарч байгаа тул тусгайлан “Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө” боловсруулах шаардлагагүйг БОННУ-д зөвлөсөн байдаг.

Хүснэгт 12 Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Төслийн үйл ажиллагаагаар түүх соёлын өвд үзүүлэх шууд сөрөг нөлөө байхгүй ч болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх шаардлагатай.	Нийт ажиллагсад компанийн “Санамсаргүй олдворын үед ажиллах журам”-г видео хэлбэрээр танилцуулсах	Үйлдвэрийн гэрээт болон туслан гүйцэтгэх компанийн ажилчид	1	200000	200000	Жилд 1 удаа (бсард)	Соёлын өвийг хамгаалах тухай хууль
Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний нийт зардал						200,000.0		

10. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Осол эрсдэлээс хамгаалах ажлын ихэнх нь төслийн үйл ажиллагааны явцад хөдөлмөрийн сахилга бат, хариуцлагын тогтолцоогоор шийдвэрлэгдэх боломжтой бөгөөд цаг уурын эрсдэлтэй нөхцөлөөс үүсэх гэнэтийн осол, цаашлаад зэрлэг ан амьтдын ослоос урьдчилан сэргийлэх ажилд холбогдох зардал нь төслийн үйл ажиллагааны зардлын санхүүжилтийн хүрээнд шийдвэрлэгдэх боломжтой юм.

Хүснэгт 12 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Цаг уурын эрсдэлтэй нөхцөлөөс үүсэх гэнэтийн осол	Цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээг тогтмол цахим хэлбэрээр хүргүүлэх	Үндсэн болон гэрээт ажилчид	удаа	32	Үйл ажиллагааны зардал		10 хоног тутамд 1 удаа	
2	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зөрчил	Ажиллагсдыг ХХАА-ны хувцас хэрэгслээр бүрэн хангах, хэрэглүүлж хэвшүүлэх	Уурхайн 42 ажилтан	удаа	2	Үйл ажиллагааны зардал		Жилд 2 удаа	Аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 2008 он “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Нэр томьёо тодорхойлолт” MNS 4967:2000
3		Төслийн бүх ажилчдад өдөр бүр ажиллэхээс өмнө ХХАА-ны зааварчилгаа өгч гарын үсэг зуруулах, ХХАА-ны зааварчилгаанд хамрагдаагүй ажилчдыг тухайн өдөрт ажиллахыг хориглох	Үндсэн болон гэрээт ажилчид	-	-	Үйл ажиллагааны зардал		Өдөр тутам	
4		Элс тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдалд байнгын хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд засвар үйлчилгээг хийлгэсэн байх, аюулгүй ажиллагааны шаардлага хангасан техник тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийг үйл ажиллагаанд ашиглах	Элс тээврийн 3 норд	-	-	Үйл ажиллагааны зардал		Тогтмол	
5		Ажилчдад анхны тусламж үзүүлэх арга зааврыг эзэмшүүлэх	Уурхайн 42 ажилтан	удаа	1	Үйл ажиллагааны зардал		Жилд 1 удаа	
6	Тоног төхөөрөмжид эвдрэл, гэмтэл үүсэх	Тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, ашиглалтын хугацаанд хяналт тавьж ажиллах	Угаан баяжуулах хэсэг	-	12	Үйл ажиллагааны зардал		Сард 1 удаа	MNS 5566:2005 Гал түймрээс хамгаалах. ААН, байгууллага, барилга
7	Гал түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж иж бүрэн байлгах	Гал түймрийн осол, аюулаас урьдчилан сэргийлж, сургалтыг зохион байгуулах	Уурхайн барилга байгууламж, баяжуулах хэсэг	удаа	2	100,000.0	200,000.0	Жилд 2 удаа (6.9 сард)	байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн

8		Болзошгүй аюул ослын үед ашиглах бүрэн ажиллагаатай гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл, хор саармагжуулах бодис, уусмалыг байрлуулах		ширхэг	12	Үйл ажиллагааны зардал		Сар бүр	зайлшгүй байх шаардлага, норм	
9	Аянга цахилгаанд нэрвэгдэх	Аянга зайлуулагчийг ойролцоох өндөрлөг газруудад суурилуулах, цахилгаан дамжуулах хийцлэлтэй материалтай болон цахилгаан гүйдэл бүхий тоноглолуудыг бүгдийг нь стандартын дагуу газардуулсан байх, Аянга зайлуулагчийн хэвийн ажиллагааг 1 удаа мэргэжлийн байгууллагаар шалгуулж, найдвартай ажиллагааг хангах	Уурхайн талбайд ашиглаж буй тоног төхөөрөмж газардуулга	удаа	1	300,000.0	300,000.0	Жилд 1 удаа (8 сард)	Утсан холбооны төхөөрөмж түүн дээр ажиллагсдыг атмосферын цэнэгжилтээс хамгаалах арга MNS 4026:1987	
Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө нийт зардал								500,000.0		

11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн болон ахуйн хог хаягдлаас үүсч болзошгүй нөлөөллийг бууруулах зорилгоор эх үүсвэр дээр нь хог хаягдал гарахаас урьдчилан сэргийлэх, бууруулах, дахин ашиглах, дахин боловсруулах шаталсан менежментийн зарчмыг хэрэгжүүлж байна.

Үүний хүрээнд хог хаягдлыг төрөлжүүлэн ангилан ялгах боломжтой, стандартын шаардлага хангасан түр хогийн цэгийг байгуулж, хог хаягдлыг гэрээт байгууллагад тогтмол нийлүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Хүснэгт 13 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (төгрөг)	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ахуйн	Хог хаягдлын менежмент сэдэвт сургалтыг зохион байгуулах	42 ажилтан	удаа	1	100,000.0	100,000.0	Жилд 1 удаа	“Хог хаягдлын тухай” хууль, “Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тэвэрлэх, дахин боловсруулах, сэргээн, ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага”, “Хог хаягдлын улсын мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоо, бүрдэл болон мэдээлэл төвлөрүүлэх журам” Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тэвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам
		Хуванцар, шил, лааз, поошигийг "Төвшин Сайхан" ТББ-т тогтмол нийлүүлэх	Үйлдвэрийн талбай	удаа	2	150,000.0	300,000.0	Жилд 2 удаа	
2	Аюултай	Тосолгооны материалаар бохирдсон бээлийн арчих материалыг "Түмэн Эгшиг" ХХК-д нийлүүлэн устгалд оруулах	Засварын байр	удаа	3	Үйл ажиллагааны зардал		Тухай бүр	“Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний нийт зардал
		Хаягдал тос маслыг шаардлагын дагуу цуглуулж "Об ойл" ХХК-д нийлүүлэх	Хаягдал тос цуглуулах сав	удаа	1	-	-	Жилд 1 удаа	
3	Ахуйн бохир	"Чандмань Налайх" ОНӨААТҮГ-т гэрээг сунгуулан, гэрээний дагуу нийлүүлэх	Ахуйн бохир цуглуулах 80 тн ёонкс	удаа	-	Үйл ажиллагааны зардал		Улиралд 1 удаа	
Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний нийт зардал							400,000.0		

12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хүснэгт 14 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Шинжилгээний төрөл	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж зардал төг	Нийт зардал төг	Хэрэгжүүлэгч	Хамтран хэрэгжүүлэгч	Баримтлах хууль стандарт
1	2	3	4	5	6	7	8	9	
1. Хөрс									
1.1	Хөрсний агрохимийн үндсэн үзүүлэлтүүд	Шимт хөрсний овоолго, Засварын талбай, хогийн цэг, Уурхай орчимд	удаа	2дээж 4 удаа	514000	2,056,000	Дэнжийн элсний уурхай	"Трү Ти Ар Си" ХХК	MNS5850:2008
1.2	Хөрсний физик үзүүлэлт		удаа	2дээж 3 удаа	70000	210,000			
1.3	Хүнд элементийн шинжилгээ /12элемент/		удаа	2дээж 2 удаа	70000	140,000			
1.4	Дээж бэлтгэл		удаа	2дээж 4 удаа	9000	36,000			
	Дүн					2,442,000			
2. Агаар									
2.1	NO ₂ ,SO ₂	Олборлолтын талбайн ойролцоо, шигшүүрийн дэргэд, дотоод тээврийн зам	удаа	2 дээж 4 удаа	114000	228,000.0	Дэнжийн элсний уурхай	БОХЗТЛ	Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS4585:2007
2.2	Тоос PM ₁₀ , PM _{2.5} , TSP		удаа	3 дээж 8 удаа	20000	160,000.0			
2.3	Дуу чимээ		удаа	2 дээж 3 удаа	135000	405,000.0			
	Дүн					793,000.0			
3. Ус									
3.1	Усны хими	Гүний худаг	удаа	3 дээж 4 удаа	94500	1,080,000.0	Дэнжийн элсний уурхай	"Трү Ти Ар Си" ХХК Усны хяналтын төв лаборатор	MNS 0900:2018 MNS 6561:2015
3.2	Унд ахуйн нян судлал	Гүний худаг	удаа	3 дээж 4 удаа	105000	420,000.0			
3.3		Бохирын цооног	удаа	4 удаа	35000	105,000.0			
3.4	Хүнд металлын шинжилгээ	Гүний худаг Бохирын цооног	удаа	1 дээж 4 удаа	390000	1,560,000.0			
	Дүн					3,165,000.0			
Нийт дүн					6,400,000				

**13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт 15 БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Авах арга хэмжээ	Хугацаа, давтамж	Урьдчилсан зардал, төг	Хэрэгжүүлэгч	Гарах үр дүн
	1	2	3	4	5
1	Байгаль орчны менежментийн тогтолцоог сайжруулах талаар мэдлэг, ойлголтыг ажилчдад өгч байх.	Жилийн турш	100,000	БОТХМ	Уурхайн ажилчид 4 удаагын давтан зааварчилгаанд 4 өөр сэдвээр мэдлэг ойлголтыг дэлгэрэнгүй авах
2	Сургалтын төлөвлөгөөг батлуулж төлөвлөгөөний дагуу нийт ажиллагсдад сургалтыг тогтмол орж байх	Улирал тутам	100,000		
3	Ус ашиглалтын дүгнэлт гаргуулан, гэрээ байгуулах	1-р улирал	Үйл ажиллагааны зардал	Ерөнхий инженер БОТХМ	Усны тухайн хуулийн 28.4 заалтыг хэрэгжүүлэх Хуулийн нийцлийг хангасан хүчин төгөлдөр ус ашиглах дүгнэлт, зөвшөөрөл, гэрээтэй болох
4	Ус ашиглах зөвшөөрөл авах				
5	Ус ашиглах гэрээ байгуулах				
6	Хаягдал усны дүгнэлт гаргуулах, зөвшөөрөл авах	2 улирал	100,000	БОТХМ	Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 6.1-ийн хэрэгжилтийг хангах
7	Байгаль орчны аудит хийлгэх	9 сар	-	БОТХМ	Байгаль орчныг хамгаалах тухай" хуулийн 101-р зүйл
	Нийт		300,000		

**14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ
ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ
ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ**

Хүснэгт 16 БОМТ тайлагнах хуваарь

№	БОМТ,БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнахад оролцогч талууд	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан ажилтан	Зохион байгуулах газар
1	2	3	4	5	6	
1	БОТХГ-т БОМТ-ний явцыг тайлагнах	БОМТ-ний хэрэгжилтийн явц, холбогдох мэргэжил арга зүйн зөвлөгөө авах, асуудал шийдвэрлүүлэх	14 хоногт 1 удаа	-	БОТХМ	Microsoft Teams
2	Налайх дүүргийн 5-р хорооны иргэд, нөлөөллийн бүсийн оршин суугчид	БОМТ, БОМТ-ний хэрэгжилт цаашид БО хамгаалах асуудлаар зөвлөлдөж тэдний саналыг авч хамтран ажиллах	2026.10.15	100,000.0	Ерөнхий инженер БОТХМ	Налайх дүүргийн 5-р хорооны ИНХ-ийн танхим
3	БОУӨАЯ, Төв аймгийн БОГ, орон нутгийн удирлагад БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах	Төлөвлөгөөт ажлын тайлан, биелэлтийн үр дүн, дараа жилийн БОМТ	2026.11.01	100,000.0	Ерөнхий инженер БОТХМ	Уурхайн зоогийн газар Цахим систем /eic.mn/
Нийт				200,000.0		

15. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ

Хүснэгт 17 БОМТ зардал

№	Үйл ажиллагааны зардал	Төлөвлөсөн зардлын хэмжээ, мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх	3,480,000.0
2	Орчны тохижилт ногоон байгууламжын төлөвлөгөө	300,000.0
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	20,000,000.0
4	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	200,000.0
5	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	500,000.0
6	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	400,000.0
7	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх	6,400,000.0
8	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх	300,000.0
9	БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	200,000.0
Нийт зардал		31,780,000.00